

ХОТ АЙЛ - МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ НИЙГМИЙН ӨВӨРМӨЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Б.ГАНТӨМӨР

МУИС, ШУС, Философийн тэнхим

ТҮЛХҮҮР ҮГ: *Монгол уламжлал, хот айл, ураг төрөл, нүүдэл, социаль бүтэц, мал аж ахуй, газар бэлчээр*

ТОВЧ АГУУЛГА: *Нүүдэлчдийн нийгмийн байгууллын өвөрмөц онцлогийн тухай асуудлыг онол, арга зүйн шинэ хандлагын үүднээс авч үзэх нь өнөөгийн нэгдмэл бөгөөд олон хэмжээст дэлхий ертөнцийн хөгжлийн шинэ хандлагатай уялдуулан боловсруулахад арга зүйн учир холбогдолтой болох юм. Монголын уламжлалт хот айлын тогтолцоо нь нүүдлийн соёлын эдийн засгийн суурь харилцаа болох газар өмчлөлийн хэлбэр (ашиглах, эзэмших утгаар) хийгээд давхаргын харилцааны цогцолбор илэрхийлэл болсон нийгмийн социаль бүтэц, социаль үзэгдлүүдийн онцлог байдлыг тодорхойлох үндсэн хүчин зүйл болж байсан гэж үзэж болно. Нүүдэлчдийн газар өмчлөлийн асуудал олон жилийн турш судлаачдын анхаарлыг татсаар ирсэн бөгөөд өнөөдөр хүртэл нэг мөр цэгцэрсэн дүгнэлтэд хүрч чадаагүй байгаа билээ.*

Монголын нүүдэлчдийн нийгмийн байгууллын мөн чанар онцлогийг судлах үндсэн дээр орчин үеийн хөгжлийн үндэсний хувилбарын онол, шинжлэх ухааны үндэс болохуйц нэгдмэл онол үзэл баримтлал боловсруулах шаардлага өдрөөс өдөрт чухал болж тавигдсаар байна.

Монголын уламжлалт нийгмийн байгууллын уламжлал хийгээд онцлогийг судлахад хот айлын зохион байгуулалтын хэлбэрийг тойрч гарах боломжгүй юм. Энэ талаар судлаач эрдэмтдийн туурвисан олон арван бүтээл бий. Монголын нэрт түүхч Д.Гонгор агсан "Хот айл бол газар нутаг эдэлбэрлэх үндсэн нэгж мөн" гээд түүнийг "төрийн засаг цаазанд ер тусгагдаагүй боловч газар нутаг, түүний эрх харилцааны бөөн цогцолбор асуудлын нэгэн чухал бичил эс махбод болно" гэж үзжээ (Гонгор1978: 297). Монголын уламжлалт нийгэмд хот айл нь аж ахуйн зохион байгуулалтын бүтцийн анхдагч

гол нэгж байсныг нэрт түүхчийн эл дүгнэлт нотлон илтгэж байна.

Монголын түүх шаштирт хот айлд хуулиар тогтоосон нутаг эзэмшлийн хилийн дээс байсангүй. Бодит амьдрал дээр газар нутаг, эд баялгийг хот айлаар хуваарилан эзэмшиж эдэлбэрлэх явдал нэн түгээмэл байлаа. Жишээлбэл, Сайн ноён хан аймгийн далай вангийн хошуунд газар нутгийг "гэрийн бууриар бус, гишгэдэг малаар нь" гэдэг зарчим баримтлан хот айлаар нь хуваадаг, түүнийг "нутгийн цуглаан"-аар хэлэлцэж шийддэг байв. Хот айл тус бүрд олгосон газар нь тогтоосон хил заагтай, хилийн ихэнх нь уулын нуруу, хамраар тогтоогддог, хэрэв нэгэн амыг өөр хот айлд өгөх болж нутгийн хил нь тал газраар гарах бол чулуугаар овоо, шав тавьдаг байжээ (Жагварал 1955: 92-93). Энэ баримтаас үзэхэд хэдийгээр төрийн хууль цаазаар зохицуулагдаагүй боловч овгийн үеийн орон

нутгийн ардчиллын хэлбэрээр хот айлын эдэлбэр газар нутгийг хуваарилан тогтоож байв. Хот айлын нутаг нь өвөлжөө өтөг - бууц, бэлчээр ус гэсэн хоёр бүрэлдвэр хэсгээс тогтож байсан аж. Айл, хот айл нь анхандаа овгийн байгууллын үлдэц шинжтэй байсан бөгөөд дараа дараагийн үедээ энэ шинж нь хадгалагдсаар ирсэн байна.

Хот айлын бүрэлдэхүүнд ихэвчлэн ураг төрлийн холбоогоор нэгдсэн хэд хэдэн өрх айл байх бөгөөд нэг нь нөгөөгөөс салж нутаглах тохиолдол гарна. Гэвч үүнээс болж хот айлын тогтолцоо эвдрэхгүй нэгэн дэвсгэр нутагт харьяалагдан аж ахуй, зан үйл, ёс заншлын олон талт харилцаагаар өөр хоорондоо нягт холбоотой байсаар байдаг. Ер нь хот айл бол монголчуудын хэдэн мянган жилийн мал маллагааны туршлагын явцад бүрэлдэн тогтсон аж ахуй эрхлэн хөтлөх шалгармал арга, газар нутаг эзэмшлийн хийгээд нийгмийн зохион байгуулалтын нэгэн өвөрмөц, үндсэн хэлбэр мөн.

Хот айлын зохион байгуулалтын нөхцөл дэх нийгмийн харилцаа ихээхэн өвөрмөц шинжтэй болохыг доктор Н.Хавх шинжилж үзээд: "Монголчууд өнө эртнээсээ нааш 2-4 өрх айлсан, зундаа арай олон тооны айл хөршлөн бууж саахалталж амьдарсаар ирсэн. Айл саахалтынхан бол гол төлөв ураг төрлийн холбоотой, үгүй юм аа гэхэд бие биеэ сайн таних, бараг ах дүү болчихсон тийм улс байдаг. Хот айлын нөхцөлд үр хүүхэд нь эцэг эхтэйгээ, залуу үе нь ахмад үетэйгээ, эхнэр нь нөхөртэйгээ өглөөнөөс орой болтол сурч, хүмүүжиж, ажиллаж хөдөлмөрлөнө. Учир нь залуу үеийг сургах, хүмүүжүүлэх, үйлдвэрлэл явуулах үйл хэрэг бүгд гэр бүл, үгүй юмаа гэхэд хот айл, саахалтаас хальж гардаггүй" гээд энэ тогтолцооны хүрээнд үйлчлэх нийгмийн олон талт харилцааг тайлбарлажээ (Хавх 1995:122). Энэ мэтчилэн хот айлын тогтолцоо нь: нэгд, овог аймгийн байгууллаас улбаатай ч нүүдэлчдийн амьдралын бодит шаардлагаар нөхцөлдсөн, хоёрт, хүмүүсийн хооронд амьдралын явцаар үүссэн социаль харилцааны өвөрмөц шинжийг илэрхийлсэн

аж ахуйн төдийгүй, нийгмийн зохион байгуулалтын өвөрмөц мөн юм.

Доктор Д.Дашпүрэвийн бичсэн "Монголын нийгмийн эдүгээжилтийн үе шат" бүтээлд хот айлыг **а.** захиргааны нэгж, **б.** үйлдвэрлэлийн нэгдэл, **в.** ураг төрлийн холбооны шинжтэй нүүдэлчдийн зохион байгуулалтын өвөрмөц хэлбэр мөн" (Дашпүрэв 1995: 24-28) гэх дүгнэлтийг хийсэн байна.

Хот айлын тогтолцооны асуудлыг манай судлаачид ийнхүү олон талаас нь хөндөж судалсан бөгөөд эдгээрээс үүдэн хот айлын тогтолцоог дараахь үндсэн шинжүүдээр тодорхойлж болох юм:

1. Бэлчээрт түшиглэсэн нүүдлийн мал аж ахуйн малчин ардыг хүрээлэн буй ертөнц-бэлчээртэй холбосон,
2. Монголчуудын бэлчээр ашиглалт, байгалийг таних ардын билиг зүйн үүднээс аж ахуйгаа эрхлэн хөтлөх арга болсон,
3. Хүн ардын нийгмийн ахуйн бичил орчин болсон,
4. Нийгэм-сэтгэл зүйн болон хүмүүжил сургалтын өвөрмөц тогтоц бөгөөд нүүдэлчин монголчуудын нийгмийн овгийн байгууллын уламжлал шинэчлэлийн нэгдлийг илэрхийлсэн, монголчуудын нутаг - нүүдэл хөршлөлийн өвөрмөц хэлбэр мөн гэсэн тодорхойлолт хийж болох байна.

Монголын уламжлалт нийгмийн овгийн байгууллын шинжийг түүний эдийн засгийн харилцааны суурь үндэс болсон газар нутгийг өмчлөх төвлөрсөн том хэлбэр болох төрийн өмчийн газрын харилцаатай холбон ойлгох учиртай.

Нүүдлийн мал аж ахуйд суурилсан нийгмийн нөхцөлд газрыг өмчлөх харилцаа суурьшмал амьдрал зонхилсон тариалант улс түмнийхээс нэлээд өөр, өвөрмөц онцлогтой билээ.Манай түүх судлалд энэ онцлогийг дурьддаг бөгөөд XI-XIV зууны эхний хагас орчимд монголд хэлбэршсэн газрын харилцааны тогтолцоог ерөнхийд нь:

- а. Угтаа эзэн хааны өмч байсан мянганы газар нутаг,

б. Хаан болон алтан ургийн гишүүдийн эзэмшил болгон авсан харьяат газар,

в. Онцгой гавьяат үйлс бүтээсэн шадар хүмүүст эзэмшүүлж дархалсан газар гэж ялган үздэг.

Газар өмчлөлийн асуудлыг авч үзэх ийм байр суурь нь нүүдлийн мал аж ахуйн нийгмийн үйлдвэрлэлийн системд үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл нь газар нутаг байсан (Гонгор 1978: 325) гэх тодорхойлолттой цаад утга агуулгаараа ижил байна.

Малыг нүүдлийн аргаар маллаж түүний ашиг шимийг боловсруулах замаар бүтээгдхүүний үйлдвэрлэл явуулдаг уламжлалт нүүдэлчдийн хувьд өмчийн үзэгдэл нь генезис утгаараа мал – үйлдвэрлэгч - бэлчээр гэсэн харилцаатай байдаг (Болд 1989) гэсэн сонирхолтой санал дэвшүүлж байгаа судлаачид бий. Ийм санал дэвшүүлэгчид газар - бэлчээрийн "өмчлөл" бол газрыг боловсруулах замаар бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулдаг суурин тариалангийн нөхцөл дэх газар өмчлөлийн үзэгдлээс эдийн засгийн агуулгаараа зарчмын ялгаатай зүйл гэдгийг онцлон тэмдэглэжээ. Учир нь байгалийн онгон төрхөөрөө нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн нэн чухал хэрэгсэл болсон биологийн нөхөн үйлдвэрлэлийн үндсэн орчин болох газар нь бэлчээр хэлбэртэйгээр үйлдвэрлэлийн үйл явцад татагдан оролцож байгаа тул "газар - бэлчээрийн өмчлөл" бол зөвхөн эрхийн заримдаг хэлбэрээс хол хэтрэхгүй юм (Болд 1992: 12) гэж үзсэн байна. Судлаач Д.Төмөртоогоо "... Монголд анх өмчийн харилцаа европ дахинаас огт өөрөөр үүссэн байна. Анх хувийн өмч нь Европ дахинд газар өмчлөлөөр үүссэн байхад монголд мал өмчлөлөөс эх авсан байна ... Монголчууд өнөө хэр нь бэлчээрийг Европ дахины газар өмчилдөг сонгодог хэлбэрээр өмчилдөггүйг хэн бүхэн сайн мэдэх билээ. Үүнээс уламжлан өмчийн харилцаа, өмчлөх сэтгэлгээнд өөрийн гэсэн онцлог бий" (Төмөртоогоо 1991: 52-53) гэж тэмдэглэсэн байдаг.

Оросын нэрт монгол судлаач, Академич Владимирцов Монголд феодалын харилцаа оршин байсныг хөндөхдөө суурин тариалангийн болон нүүдлийн мал аж ахуйн нөхцөлд газрын харилцаа адилтгагшгүй шинж чанартайг удаа дараа дурдсан (Владимирцов 1936: 160) байдаг.

"Их засаг" зэрэг эртний монголын хууль цаазын бичигт ч газар өмчлөлийн харилцааг зохицуулж байсан журам гэх юм нэн ховор байдгийг судлаачид тэмдэглэсэн байна.

Монголын түүхийн нэн гол сурвалж бичгийн дурсгал болох "Нууц товчоо" хийгээд "Судрын чуулган" зэрэг сурвалж хэрэглэгдхүүнийг энэ чиглэлээр шүүн судалсан эрдэмтдийн бүтээлээс үзэхэд газрын харилцаа нь оршин суугаа орон нутаг, өвөлжөө бууц, малын бэлчээр нутаг, байгаль орчин, цаашилбал, нүүдэлчин иргэдийг хамарсан утгатай байсныг тодруулсан байдаг. Энэ нь тухайн үед газар нутгийг эзэмшин харьяалах явдал феодал ёсны газар өмчлөлийн хэлбэрээс үлэмж ерөнхий, өргөн хүрээтэй үзэгдэл болохыг харуулж байна. Эндээс нүүдэлчдийн уламжлалт нийгмийн байгууллын газар өмчлөл буюу газрын харилцааны асуудлыг мөнөөх л хот айлын аж ахуй зохион байгуулалтын хэлбэртэй холбож үзэх нь зөв гэсэн дүгнэлт урган гарч байна. Энд хоёр зүйлийг зориуд анхаарах ёстой.

Нэгд, Монголчуудын түүхийн бүхий л үед газрын бүрэн эрхт дээд эзэн нь гагцхүү эзэн хаан буюу монголын төр байжээ. Чухамдаа бол дээр дурьдсан эзэн Чингисийн үеэс уламжлалтай мянганы газар, алтан ургийн гишүүдийн газар, онцгой гавьяа байгуулсан шадар хүмүүсийн эзэмшил газар гэх зэрэг нь тэр үеийн төрийн зохион байгуулалтын бүтцээр төрийн өмчийн газрыг хуваарилсан хэрэг. Орчин үеийн ойлголтоор бол энэ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн агуулгатай дүйх аж. Тодорхой нэг газар нутгийг харьяалан эзэмшиж буй хүн түүнийхээ өчүүхэн ч хэсгийг эзэн хааны зөвшөөрөлгүйгээр харь гүрэнд таслан өгөх эрхгүй байсныг манай түүхийн бүх баримт гэрчилдэг. Газар өмчлөх тухай асуудлыг

өвлүүлэх, барьцаалах, бэлэглэх, худалдан арилжих гэсэн захиран зарцуулах эрхийн орчин үеийн утгын үүднээс авч үзвэл монголын хаадын аль ч үеийн түүхэнд төрийн тэргүүн их хаанаас бусад ямар ч хүн ийм эрх дархтай байсангүй.

Хоёрт, Монгол оронд газрын шууд өгөөж баялгийг ашиглах, эзэмших ихээхэн өвөрмөц маягийн харилцаа үйлчилж байжээ. Өөрөөр хэлбэл, монголчууд газрыг эдийн засгийн харилцаа буюу аж ахуйн эргэлтэд оруулахдаа газрыг өөрийг нь биш, түүний өгөөж баялаг, үр шимийг нь ашиглах эзэмших харилцаанд л оруулж байсан хэрэг. Энэ харилцаа аж ахуй зохион байгуулалтын тодорхой хэлбэрүүд буюу субъектүүдээр дамжин хэрэгжинэ. Монголын уламжлалт нийгмийн нөхцөлд ийм субъект нь юуны өмнө хот айл юм. Хот айлын газартай харьцаж түүний өгөөж шимийг эзэмшин ашиглах хэлбэр нь тариалангийн аж ахуйн нөхцөл дэх газрын эзэн тариачдын хоорондох харилцаанаас ихээхэн ялгаатай байдаг.

Нүүдэлчдийн нийгмийн байгууллын онцлогийг тодруулахад тухайн нийгмийн байгууллын социаль харилцаа, социаль бүтцийн асуудал гол үндэслэл болдог. Монголын түүхийн бүтээлүүдэд XI зууны үе гэхэд талын язгууртан, хаад, ноёдоос үүсвэрлэн хөгжиж, хаан, хааны ураг, их бага, ноёд, "нөхөр", "дархан", "хүргэд", чинээлэг язгуур угсаатан, цэргийн эрхтнүүд, "харц ард", "урт гарын хүн", "боол", "гэрийн хүн", "инж" зэрэг нийгмийн бүлгүүд байсныг дурдсан байна. Манай түүхийн сурвалж бичигт түгээмэл тохиолддог, хүмүүсийг ямар нэг бүлэглэлд хамаатуулах эдгээр нэрийн зүйл нь тодорхой хүний нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, нийгмийн дүр төрхийг ямар нэг байдлаар илэрхийлэх нь эргэлзээгүй. Гэхдээ энд Монголын нийгмийн байгууллын уламжлалт цөм болсон хот айлын зохион байгуулалтын өвөрмөц онцлогтой холбоотойгоор онолын хувьд нягтлан үзэж практик шинжилгээнд бодолцож үзүүштэй зарим асуудал байгаа юм.

Онолын хувьд бол хүмүүсийг янз бүрийн бүлэглэлд ангилан үзэх өдий төдий шалгуур үзүүлэлт гаргаж болно. Гэхдээ эдүгээ хүн төрөлхтний нийгмийн шинжилгээнд:

а/ нийгмийн эдийн засгийн үзүүлэлтүүд (хөрөнгө чинээний ялгаа, эдийн засгийн болон улс төрийн эрх мэдэл, нийгмийн үйлдвэрлэл хийгээд зохион байгуулалтын системд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг г.м.)

б/ Нийгэм - хүн ам зүйн үзүүлэлтүүд (угсаа гарал, нас, хүйс, хэл, соёл, зан заншил, үндэсний ухамсар, сэтгэл зүйн онцлог г.м) - ийг хэрэглэн тухайн ард түмний нийгмийн бүтцийг судлах явдал түгээмэл байна.

Үүний эхний бүлэг үзүүлэлт нь ихэвчлэн нийгмийн ангийн бүтэц буюу анги, давхраа, нийгмийн бүлгүүдэд хүмүүсийг хамаатуулан үзэхэд хэрэглэгдэж буй ба хоёр дахь нь гол төлөв үндэстэн угсаатны бүтэц болон ангиас үл хамаарах нийтлэг нэгдэл, бүлгийг шинжлэхэд хэрэглэгдэж байна. Энэ хоёр бүлэг шалгуурт хамаарах бараг бүх үзүүлэлт нь Монголын хот айлын зохион байгуулалтын бүтцэд үйлчилдэг нийгмийн социаль харилцаа, социаль бүтцэд хэрэглэж болох үндэслэлтэй юм. Өөрөөр хэлбэл, манай нийгмийн онцлог бодит байдлаас шалтгаалаад эдгээр бүлэг үзүүлэлтийн аль алианаас нь авсан, бас хот айлын зохион байгуулалтын системд байдаг социаль харилцааны онцлогийг илэрхийлсэн үзүүлэлтүүдийг багтаасан шалгуурын системийг ч ашиглах шаардлага гарна. Ер нь аль ч улс орны нийгмийн бодит байдалд шууд тохироод байдаг тийм түгээмэл шалгуур гэж байдаггүй. Чухам ямар шалгуурыг барьж, яаж ангилж бүлэглэх вэ гэдэг нь гагцхүү тухайн үеийн түүхэн тодорхой нөхцөл дэх амьдралын бодит байдал, нийгмийн ялгарлын үйл явцыг дэлхийн хөгжлийн туршлага, ерөнхий хандлагатай жишин үзсэн ерөнхий шинжилгээ ба тухайн судалгааны зорилго, чиглэлээс шалтгаалах зүйл юм.

Монголын түүхийн сурвалж бичигт буй хүнийг тодорхой бүлэгт хамаатуулсан нэр томъёолуудын агуулгыг нарийвчлан үзвэл

гэр бүл, ураг төрөл, хот айл, язгуур угсааны хамаарал, улс төрийн эрх хэмжээ, эд хөрөнгийн байдал, эрхэлж буй үйл ажиллагаа зэрэг олон янзын шалгуурыг хольж барьсан байдал илэрхий байна. Тэгэхээр дээр дурьдсан хамаатал нэр бүрийн цаана нийгмийн нэг биеэ даасан анги, бүлэг байна гэх юм уу эсвэл хэдэн гол шинжээрээ ойролцоо бүлгүүд нийлээд нэг анги үүсгэж байна гэж үзэхийн аль аль нь дэндүү механик дүгнэлт болох талтай.

Монголын нийгэм бол нүүдэлчдийн өвөрмөц онцлог бүхий уламжлалт нийгэм. Европод ч юм уу, аль нэг хөгжилтэйд тооцогдож буй суурьшмал соёл иргэншилтэй улс оронд байсан нийгмийн бүтцийг монголын нүүдэлчдийн нийгмийн бүтэц, социаль харилцаа заавал бий болгож байх албагүй юм. Нүүдэлчдийн нийгмийн харилцаа ч тийм бүтцийг бий болгоогүй, тэрчлэн өөр орчин, өөр соёл иргэншилтэй улсын нийгмийг задлан шинжлэх явцад боловсорсон онолын (тухайлбал, нийгмийн ангийн бүтцийн) загварыг "батлах" баримт сэлтийг монголын түүх, амьдралаас түүвэрлэх замаар дүгнэлт хийж болохгүй.

Дээр дурьдсан зүйлийг нягтлан эрэгцүүлбээс монголын нүүдэлчдийн амьдрах соёлын тогтолцоо түүнд зохицсон нийгмийн байгууллын хөгжлийн талаар дараах ерөнхий таамаглал дэвшүүлж болмоор байна.

Нэгд, Монголын нүүдэлчид төр улсаа эмхлэн байгуулахдаа харь орны аль нэг загварыг хуулбарлан дагасангүй. Энэ бол монголын нийгмийн овгийн байгууллын өвөрмөц шинжийг тодруулан судлах суурь үндэс мөн. Монголчууд өөрийн түүхнээ уламжлагдан бий болсон амьдрах соёлын тогтолцоо буюу байгаль газар зүйн орчин нөхцөл, аж ахуйгаа эрхлэн хөтлөх арга ухаан, ард түмний зан заншил, уламжлалт ёс суртахуун сэтгэл зүйн язгуурын онцлог шинж, хүмүүсийн хоорондын харилцаанд хэвшиж тогтсон хэм хэмжээ зэрэг олон хүчин зүйлийг нягт харгалзан эдгээрт зохицож нийцсэн төр улсын зохион байгуулалтын тэр

л хэлбэрийг бий болгон төгөлдөржүүлж иржээ. Тэгэхдээ тухайн түүхэн цаг үеийн дэлхий дахины төр улсын зохион байгуулалтын нийтлэг жишгийг өөрийн үндэсний хөрс сууринд зөв зохицуулан тусгахыг ч бас орхигдуулсангүй. Түүхэн баримт сэлтийг мөшгөн үзвээс нүүдэлчин монголчууд соёл иргэншлийнхээ агуулга, мөн чанарт нийцсэн төр улсын сонгодог хэлбэрийг бий болгон хөгжүүлсэн нь XI зууны үе буюу Чингисийн байгуулсан монголын тулгар төрийн үед холбогдоно. Энэ бол хүн төрөлхтний түүхнээ нүүдлийн нийгмийн байгууллын мөн чанарыг илэрхийлсэн төр улсын зохион байгуулалтын бие даасан өвөрмөц хувилбар байв. Энэхүү хувилбарын олон чухал зарчим нүүдлийн соёл иргэншлийн уламжлал, шинэчлэлийн олон зуун жилийн түүхнээ цаг хугацааны болон нийгмийн өдий төдий сорилтыг үзэн эдүгээ бидний үед бүдгэрсэн хэдий ч уламжлагдан иржээ.

Хоёрт, Газрыг хот айлын зохион байгуулалтаар ашиглах нь чухамдаа хамтын шинжтэй зохион байгуулалтын хэлбэр байдаг. Монголын уламжлалт нийгмийг нүүдэлчдийн нийгмийн байгууллын сонгодог хэлбэр болон хөгжихөд хот айлын тогтолцоо нь түүний анхдагч бөгөөд хамгийн гол гол онцлогийг илэрхийлсэн нийгэм, иргэншлийн зохион байгуулалтын хэлбэр байжээ гэх үндэстэй байна.

Гуравт, Монголчуудын газартай харьцах харилцаа хөгжлийн үе шат бүрд өвөрмөц онцлогтой нийгмийн нарийн утга учиртай байв. Түүнд овгийн байгууллын уламжлалт шинж нэлээд тод үлдэж хоцорчээ. Газартай харьцах харилцаа нь юуны өмнө өмчлөлийн харилцаа. Энэ нь суурин тариалангийн болон нүүдлийн мал аж ахуйн нөхцөлд адилгүй хэлбэрээр хэрэгждэгээс нийгмийн учир утга нь ч их л өөр аж.

Дөрөвт, Хүний нийгэм социаль бүрдлүүдэд хуваагдах болсон нь нэлээд эртний үзэгдэл. Энэ явцад нийгмийн янз бүрийн социаль бүлэг давхраанууд бий болдог нь жам ёс. Хүмүүсийг янз бүрийн анги, нийгмийн социаль бүлэгт хамааруулах

дэлхий нийтийн жишгийг тусгасан түгээмэл шалгуурын зэрэгцээ тухайлсан улс үндэстний өвөрмөц онцлогийг илэрхийлсэн тодорхой үзүүлэлтүүд ч бий. Ийм хоёр шалгуур үзүүлэлтийн системийг зөв хослон барьж тухайн улс орны нийгмийн социаль харилцаа, социаль бүтцийг тодорхойлдог. Улмаар нийгмийн социаль бүтцийг үүсгэж буй харилцааны систем нь улс төрийн тогтолцооны ерөнхий шинж төрхийг нэлээд тодорхой илэрхийлнэ. Тэгвэл нүүдэлчин

монголчуудын хувьд хүмүүсийг нийгмийн социаль бүлэгт хамаатуулахдаа нийгэм-эдийн засгийн үзүүлэлтийн зэрэгцээ язгуур угсаа, ургийн холбоо, үе залгамжлал зэрэг уламжлалт үзүүлэлтүүд чухалд тооцогддог. Нийгмийн улс төрийн харилцаа энэ байдлыг тусгана. Монголчуудад төр засаг, өвөг дээдэс, ахмад үеэ хүндэтгэн дээдлэх сэтгэлгээ ихээхэн хүчтэй байдаг нь чухам үүнтэй холбоотой.

НОМ ЗҮЙ

- Болд Б.*, 1989. Монголын нүүдлийн МАА-н үйлдвэрлэл дэх үйлдвэрлэлийн хэрэгслийн бүрэлдэхүүнийг судлах арга зүйн асуудалд. *ШУА-ийн мэдээ*. 1989, № 4
- Болд Б.*, 1992. Монголын феодализмын шалгуурын тухай асуудлаар маргах нь. *Бодрол бясалгал*. 1992, № 2, х. 12
- Владимирцов Б.Я.*, 1936. *Общественный строй монголов*. П.
- Гонгор Д.*, 1978. *Халх товчоон*. 2 боть. УБ.
- Дашпүрэв Д.*, 1995. *Этапы модернизации монгольского общества*. УБ. х. 24-28
- Жагварал Н.*, 1955. *Земельные отношения в Монгольской Народной Республике*. УБ. х. 92
- Төмөртоогоо Д.*, 1991. Монголын эдийн засгийн түүх, сэтгэлгээ. *Үндэсний эдийн засаг*. 1991, № 1, х. 52-53
- Хавх Н.*, 1995. *Монголчуудын соёл иргэнилийн гүн ухаан*. УБ. х.122

SUMMARY

B.GANTUMUR

HOT AIL – A SPECIFIC ORGANIZATION OF THE TRADITIONAL SOCIETY IN MONGOLIA

In the paper, the author discusses the issues on the peculiarity of nomadic peoples' social structure from the new tendency of theoretical and methodological points of view that have a methodical importance connecting to the integrated and multidimensional world of today. Structure of the Mongolian traditional way of camping in 'hot ail' is considered to be the main factor for defining the land owning form as the basic relationship of nomadic culture and economy, and a complex expression of the social structures and phenomena of the society.